

26

Нөхөн үржихүйн болон бэлгийн эрүүл мэнд

Та ажилгаа
химийн бодис
хэрэглэдэг үү?
XXX таныг
хамгаалах болно.

Гэвч юу миний
хүүхдийг
хамгаалах
бол?

ЭНЭ БАЙГУУЛАМЖИД
БАЙГАА ХИМИЙН БОДИС
НЬ ДАРААХ ХҮҮҮҮСТ ХОР
НӨЛӨӨ ҮЗҮҮЛНЭ.

- АХМАД ХҮН,
- ЗАЛУУС,
- ЭМЭГТЭЙ ХҮН,
- ЭРЭГТЭЙ ХҮН,
- НЯРАЙ ХҮҮХЭД,
- ХҮҮХЭД,
- ӨСВӨР НАСНЫ ХҮҮХЭД

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН
ЭРҮҮЛ АХУЙН ХЭЛТЭС,
2023 он.



Экспортын чиглэлийн үйлдвэрийн дийлэнх ажилчид болох эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн аль аль нь гэр бүлээ тэжээх, хүүхдээ өсгөх бэлгийн идэвхтэй амьдралтай насан дээрээ байдаг. Гэвч хүмүүсийн амьдралын гол үйл ажиллагаанд анхаарал тавихын оронд олон үйлдвэрийн нөхцөл байдал нь жирэмсний хүндрэл, төрөлхийн гажиг зэрэг асуудлын шалтгаан болж, үүнээс улбаалаад залуу ажилчдыг нөхөн үржихүйн эрхтний хорт хавдар болон бусад олон өвчнөөр өвчлүүлж байна. Тийм учраас улсын болон олон улсын хөдөлмөрийн болоод эрүүл мэндийн стандартыг хэрэгжүүлдэггүй үйлдвэрүүд нь ажилчдын нөхөн үржихүйн болон бэлгийн эрүүл мэндэд аюул учруулж байна.

Ажилчдад дараах нөхцөлийг хангасан үйлдвэрүүд хэрэгтэй:

- Хувь хүн буюу эмэгтэй хүнийг жирэмсэн болсон эсвэл хүүхэдтэй гэж ялгаварлан гадуурхдаггүй.
- Жирэмсний болон төрсний дараах чөлөө, бас шаардлагатай үед хүүхдээ асрах чөлөөгөөр хангадаг.

- Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нөхөн үржихүйн эрүүл мэндийг хордуулж байгаа химийн бодисыг хор багатай эсвэл хоргүй бодисоор орлуулж, ажиллах орчныг сайжруулдаг.
- Чанартай эрүүл мэндийн үйлчилгээг авч болох сайн эмнэлэгт газар нутгийн хувьд харьяалалтай болон хүүхдийн цэцэрлэгт ойрхон байршилтай.

Ажиллах нь нөхөн үржихүйн эрүүл мэндэд нөлөөлдөг

Нөхөн үржихүйн эрхтэн химийн бодист өртсөнөөр эрүүл мэндэд нөлөөлдөг. Нөхөн үржихүйн сонголтыг хянадаг эсвэл хязгаарласан үйлдвэрийн бодлого, үйл ажиллагаа нь нөхөн үржихүйн болон бэлгийн эрүүл мэндэд хор учруулдаг.

Эмэгтэйчүүд үйлдвэрийн байранд олон бэрхшээлтэй нүүр тулдаг. Зарим дарга нар гэрлэсэн, жирэмсэн болон хүүхэдтэй эмэгтэйг ажилд авахаас татгалздаг. Зарим үйлдвэрт эмэгтэйчүүдийг жирэмсэн болохоос урьдчилан сэргийлсэн журамтай байдаг.



Тэд намайг лаборатори руу явуулж, цусны шинжилгээ авсан. Тэд хэлэхдээ "Ажиллагчдын эрүүл байгаа эсэхийг шалгах хуультай" гэсэн. Гэвч тэд намайг жирэмсэн эсэхийг үзэх гэж байгааг би мэдэж байсан. Тэд шинжилгээний хариуг шууг гарга руу явуулсан. Хэрвээ жирэмсэн бол тэд зүгээр л ажлын байр байхгүй байна гэж хэлэх болно.

Химийн бодис болон ажлын муу нөхцөл нь эмэгтэйчүүдийн сарын тэмдгийн мөчлөг алдагдах болон жирэмслэлтийн хүндрэл, үр зулбалтад хүргэх ба заримдаа хэвлий дэх хүүхдийн эрүүл мэндэд хор хөнөөл учруулдаг. Химийн бодис нь мөн хөхний, савны болон өндгөвчний хорт хавдрыг үүсгэх магадлалтай. Эмэгтэй хүний бие эрэгтэй хүнээс илүү нөхөн үржихүйн үүрэгтэй байдаг тул тэдний нөхөн үржихүйн эрүүл мэндэд химийн бодис илүү их хор хөнөөл учруулдаг.

Эрэгтэй хүн ч бас үйлдвэрийн тааруу нөхцөлд өвддөг. Химийн бодис, халуун, стресс, бас хэт олон цагаар ажиллах нь эрэгтэй хүний бэлгийн хавьталд орох хүсэл болон үр тогтоох чадварыг бууруулж (сулрал), хүүхэдтэй болох чадваргүй (үргүйдэл) болгодог. Зарим химийн бодис нь эрэгтэй хүний эр бэлгийн эсийг гэмтээж, үр зулбах эсвэл хүүхэд нь өвчтэй төрөхөд хүргэдэг. Зарим химийн бодис нь төмсөгний хорт хавдар үүсэх шалтгаан болдог.

Нөхөн үржихүйн болон бэлгийн эрүүл мэнд нь эрчүүдийн хяналтанд байдаг эмэгтэйчүүд ч нөхөн үржихүйн болон бэлгийн эрүүл мэндийн хор хөнөөлтэй нүүр тулдаг. Эдгээр нь бэлгийн эрүүл мэндийн үйлчилгээ, гэр бүл төлөвлөлтийн мэдээлэл дутмаг, гэр бүлийн хүчирхийлэл, БЗХӨ, бас хорт хавдрын эмчилгээний тусламж үйлчилгээ авах боломжгүйгээс болдог.

Эмэгтэйчүүдийн төрөлт, гэр бүлийн амьдралыг хянах

Ихэнх хүмүүсийн хувьд хүүхэдтэй болох нь тэдний бэлгийн амьдралын чухал хэсэг байдаг. Нөхөн үржихүйн эрүүл мэнд нь ялангуяа эмэгтэйчүүдэд чухал байдаг ба учир нь тэд жирэмсэлж, төрж, хүүхдээ хооллож, бас ихэнхдээ гэр бүлээ асрах үндсэн үүрэг бүхий хүмүүс нь байдаг.



Олон үйлдвэрт эмэгтэйчүүд хүүхэдтэй байх уу эсвэл ажилтай байх уу гэдгийн аль нэгийг сонгох ацан шалаанд ордог. Ажил олгогч нар нь ажилчдын биеэ авч яваа байдал, тэдний бэлгийн амьдрал болон гэр бүл төлөвлөлтийг үйлдвэрийн журмаар дамжуулан хянах оролдлого хийдэг. Тэд эмэгтэйчүүдийг ажиллаж байхдаа ээж болохоос нь урьдчилан сэргийлэхийг хичээдэг. Зарим дарга нар зөвхөн гэрлээгүй, бас хүүхэдгүй эмэгтэй хүнийг ажилд авдаг.

Хэрвээ эмэгтэй хүн жирэмсэн болбол ажил олгогч нар ихэнхдээ жирэмсэн эмэгтэйг илүү аюул багатай ажил руу явуулах, төрөхийн өмнөх болон дараах эрүүл мэндийн үзлэгт төлбөр төлөхөөс зайлсхийж, төрөхийн өмнө болон дараах чөлөө өгөлгүй тэднийг хүүхэд болон өөрсдийн эрүүл мэндээ эрсдэлд оруулан ажиллах эсвэл гэр бүлээ харахаар ажлаас гарахыг санал болгодог. Эмэгтэйчүүд аюулгүй ажил хийх, эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжгүй үед үр зулбаж, бие сэтгэлээр шаналах болон төрөлхийн хүндрэл эсвэл хүүхэд нь дутуу төрөх, тэр байтугай амь насаа алдах явдал ч гардаг.

Эрэгтэйчүүдийн ажилд хүүхэд яаж нөлөөлөх талаар тэднээс асуух нь ховор.



Бид ажилтай байхын тулд үргүй болох ёстой

Бразилд үйлдвэрийн эзэд эмэгтэйчүүдээс ажилтай болохын тулд үргүй болсон гэдгээ батал гэж хэлдэг талаар олон санал гомдлыг манай холбоо хүлээж авсан юм. Ажил олгогчид үүнийгээ ихэнх тохиолдолд амаар хэлдэг тул дараа нь ямар ч нотлох баримт үлдээдэггүй бөгөөд тэд үүнийг үгүйсгэдэг. Бусад компаниуд тухайн эмэгтэй ажилчдын сарын тэмдэг ирж байгааг баталгаажуулах “Сарын тэмдгийн үзлэг” хийдэг. Эмэгтэйчүүд өөрсдийн сарын тэмдэг ирэх ёстой өдрийг нийтийн өрөөний том самбар дээр бичих хэрэгтэй болдог. Тухайн өдрөө тэд эмч дээр очиж сарын тэмдэг ирж байгааг батлах ёстой болдог. Энэ нь гутамшигтай, бас буруу практик юм.

Хүчээр жирэмсний тест өгөх: Эмэгтэйчүүд ажилд орохоор бүртгүүлэхдээ ихэвчлэн жирэмсэн биш гэдгээ батлах ёстой болдог. Эмэгтэй хүн бүр ажил олгогчийн эмчээс түүнд шинжилгээ хийсэн тухай зөвшөөрлийн бичиг авчрах ёстой болдог. Тэд жирэмсэн эсвэл шинжилгээ өгөхөөс татгалзвал ажилд авдаггүй.

Жирэмсэлж болохгүй гэх дарамт: Зарим эмэгтэйчүүд үйлдвэрт ажиллаж байхдаа хүүхэдтэй болохгүй гэдгээ илэрхийлсэн гэрээнд хүчээр гарын үсэг зурдаг.

Дарамтлах эсвэл ажлаас халах:

Хэрвээ эмэгтэй ажилтан жирэмсэн болбол түүнийг халах буюу ажлаасаа гаргал нь дарамталдаг. Дарамттай үг хэлээр доромжлох, илүү их үйлдвэрлэлийн норм тогтоох, олон цагаар ажиллуулах эсвэл илүү хэцүү ажил руу шилжүүлэх, мөн түүнчлэн суугаа ажлаас зогсоо ажил руу эсвэл илүү халуун ажлын орчин руу шилжүүлэх зэрэг нь үүнд багтдаг.



Манай үйлдвэрт байдаг эмнэлэг биднийг жирэмсэн болохоос сэргийлсэн эм өгдөг ч ДОХ болон БЗХӨ-өөс урьдчилан сэргийлэхэд туслах бэлгэвч өгдөггүй.

Гэвч би жирэмсэн

Би хүний нөөцийн ажилтан эмэгтэйд жирэмсэн болсон гэдгээ хэлсэн ч намайг шөнийн ээлж рүү шилжүүлсэн. Миний ээлж оройн 7 цагаас өглөөний 7 хүртэл ажилладаг байсан. Хамгийн хүнд нь би үргэлж зогсож ажиллахаас өөр аргагүй байсан. Миний хүүхэд гэдсэнд бойжиж байхад 12 цаг зогсож ажиллаж байсан ба цаашдаа маш хэцүү бөгөөд өвдөж эхэлсэн. Би ахлахаасаа надад сандал өгөөч гэхэд, тэр миний гэдэс харагдаж эхлээгүй байсан учраас чиний жирэмсэн гэдэгт итгэхгүй байна гээд үгүй гэсэн. Гэвч одоо би том гэдэстэй болсон ба хэдэн долоо хоногийн өмнө намайг өдөр тутмын нормын хүснэгтийг шалгадаг хэсэг рүү шилжүүлсэн. Тэнд жирэмсэн эмэгтэйд хор нөлөөтэй хэд хэдэн химийн бодис хэрэглэдэг байсан. Би үүнийг цаашид тэсвэрлэх аргагүй байсан тул жирэмсний амралтаа ч авалгүй ажлаасаа гарсан.



Гэрээт ажилчид ба жирэмсний амралт

Би Эл Сальвадорийн ажиллах хүчний агентлагаар дамжин (түр ажилчин) үйлдвэрт ажилд орсон. Гэхдээ бусад ажилчидтай адил ажил хийдэг ч манай дарга биш, ажиллах хүчний агентлаг надад цалин өгдөг. Би жирэмсэн болох үедээ ажиллах хүчний агентлаг руу очиж жирэмсний амралтын талаар хэлэхэд тэд энэ бол танай үйлдвэрийн үүрэг гэж хэлсэн. Тэгээд үйлдвэртээ ирж энэ бол үйлдвэрийн үүрэг хариуцлага гэж ажиллах хүчний агентлаг хэлж байна гэдгийг хэлсэн. Би Центро де Эстудиос у Апоя Лаборал (CEAL)-тэй холбоо тогтоохоор шийдэх хүртэл нэг хэсэгтээ тэнд байсан. Тэд үйлдвэр болон ажиллах хүчний агентлагт хоёуланд нь гомдол гаргаж, ажиллах хүчний агентлаг нь миний жирэмсний амралтын цалинг төлөх үүрэгтэй гэдгийг тэднээр зөвшөөрүүлсэн.



Жирэмсний амралт өгөхөөс татгалзах: Олон оронд ажил олгогч нь жирэмсний амралтыг өгөх эсвэл амралтын мөнгө төлөх ёстой байдаг ч дарга нар ихэвчлэн хэрвээ тэд төрснийхөө дараа ажилдаа орохыг хүсэж байвал үүнийг авахыг нь хориглодог. Учир нь тэд шинэ төрсөн хүүхэд болон ээжид нь аавын дэмжлэг хэрэгтэй гэдгийг олж тоодоггүй ба шинэ хүүхдийн аавд чөлөө олгохыг чухал биш гэж боддог. Хуулиар ч ихэнхдээ үүнийг шаарддаггүй.

Үйлдвэрт хүүхэд харах үйлчилгээ байхгүй байх: Эмэгтэйчүүд ажлын цагаар тэдний хүүхдийг харах хэн нэгнийг заавал олох ёстой болдог. Эсвэл хүүхдээ харах хүнгүй үлдээдэг. Хэрвээ бид албан шаардлагаар илүү цаг ажиллах болбол хэн бидний хүүхдийг асарч, хооллох юм бэ?

Үйлдвэрт хөхүүл хүүхдийг хөхөөр хооллох цаг эсвэл газар байхгүй байх: Энэ нь хөхүүл хүүхдийг зөв хооллох, эх нь сүүтэй болж, хүүхэд хөхөөр хооллох чадварт муугаар нөлөөлдөг. Хүүхдийг ядаж нэг нас хүртэл нь хөхөөр хооллох хэрэгтэй.

Бангладешийн үйлдвэрүүд хүүхэд харах үйлчилгээ үзүүлдэг

Пулки нь Бангладешийн үйлдвэрүүд дотор байдаг хүүхэд харах үйлчилгээгээг зохион байгуулдаг байгууллага юм. Пулки үйлдвэрийн эздээс орон зай гаргаж, гарааны зардал, бас хүүхэд асрагчдын цалинг өгөх ёстойг ойлгуулж, ятгадаг. Хүүхэд харах үйлчилгээний хэлтсийг ашиглаж байгаа ажилтан хоол болон бусад зардалд багахан хэмжээний төлбөр төлдөг.

Пулкигийн энэ хөтөлбөр үйлдвэрт болон ажилчдад аль алинд нь ашиг тустай байсан учраас маш амжилттай байсаар байна. Энэхүү ирээдүйтэй загварыг үйлдвэр бүрт хэрэглэж болох юм. Ажилчид хүүхдээ гэрт нь ганцааранг нь үлдээх эсвэл ихэвчлэн тэдэнд үнэтэй тусдаг хүүхэд харах үйлчилгээ олох талаар санаа зовох зүйлгүй болсон. Ээж нар завсарлагааны үеэр хүүхдээ хөхөөр хооллох боломжтой болсон. Ажлын байран дээр хүүхэд харах үйлчилгээний хэсэгтэй ажил олгогч нь ажилчид ажлаасаа цөөн удаа чөлөө авч илүү үр ашигтай ажиллах болсныг олж мэдсэн юм.



Нөхөн үржихүйн эрүүл мэндэд нөлөөлдөггүй ажилтай байх эрх



ОУХБ-ын Химийн бодисын тухай конвенц (№170), Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн конвенц (№155)-д ажил олгогч нь эрүүл мэнд болон нөхөн үржихүйн эрүүл мэндэд нөлөөлөх нөхцөл болон химийн бодисоос хамгаалах ёстой гэж тус тус заасан байдаг.

ОУХБ-ын Жирэмсэн эхийг хамгаалах тухай конвенц (№183)-д:

- Төрөхийн өмнөх, төрөх үеийн, бас төрсний дараах эмнэлгийн тусламжаар эмэгтэйчүүд болон тэдний хүүхдийг заавал хангах ёстой;
- Тухайн ажил нь жирэмсэн эмэгтэйд болон тэдний хүүхдэд аюултай гэдэг нь батлагдсанаас бусад нөхцөлд хүчээр жирэмсний шинжилгээ авахыг хориглох.

НҮБ-ын Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (CEDAW) -д зааснаар улс орнуудад жирэмсэн эмэгтэйчүүд заавал дараах байдлаар хамгаалагдах ёстой:



Нөхөн үржихүйн эрүүл мэндэд нөлөөлдөггүй ажилтай байх эрх

(үргэлжлэл)



- Эмэгтэйчүүдийг жирэмсэн эсвэл тэд жирэмсний амралт авах болсон учраас ажил олгогч халах нь хууль бус;
- Эмэгтэйчүүдийг жирэмсэн үед, тодорхой төрлийн хор нөлөөтэй нь батлагдсан ажлаас тусгайлан хамгаалах.

Ажилчдын эрхийг дэмжих олон улсын байгууллага НҮБ, ОУХБ-ын үүргийг
Хавсралт А-д тайлбарлав.



Химийн бодис

Өнөө үед хэрэглэгдэж байгаа ихэнх химийн бодис нь нөхөн үржихүйн болон бэлгийн эрүүл мэндэд хэрхэн нөлөөлдөг эсэх нь судлагдаагүй байна. Химийн бодисын үйлдвэрүүд ихэвчлэн эрүүл мэндийн судалгааг эсэргүүцэж, тэдний гаргасан зохицуулалт болон аюултай химийн бодисыг хориглосон шийдвэр ашиг орлого, эрхийг нь шударга бусаар хязгаарлаж байна гэж үздэг.

ХАБЭА-н мэргэжилтнүүд нь өөрсдөдөө болон үйлдвэрийн удирдлага, мөн ажилчдад химийн бодисын судалгаа болон ажилдаа үргэлж илүү аюул багатай химийн бодис хэрэглэх боломжийн талаар мэдлэг олгоход чухал үүрэг гүйцэтгэж байна.

Ажил таныг үргүй болгох уу?

Би электроникийн үйлдвэрийн битүүмжлэлтэй өрөөнд ажилладаг. Бид нимгэн талст ялтас химийн бодист дүрж компьютерын чип хийдэг. Ажил дээрээ хэдэн сар байсны дараа миний сарын тэмдгийн хугацаа алдагдаж эхлэв. Өмнө нь тогтмол байдаг байсан. Гэвч хэзээ ч хамаагүй ирдэг болж эсвэл огт ирэхээ больсон. Нэг удаа би бүүр өөрийгөө жирэмсэн болчихож, одоо ажилгүй болох байх гэж хүртэл бодлоо. Манай үйлдвэрт жирэмсэн эмэгтэйчүүд халагддаг. Тэгээд эцэст нь нэг юм миний сарын тэмдэг ирсэн. Гэвч жил орчмын өмнө миний сарын тэмдэг ирэхээ больсон. 5 сар өнгөрсний дараа би хамтран ажиллагчдынхаа нэгэнд хэлсэн. Тэр ч мөн над шиг адилхан асуудалтай гэж хэлсэн бөгөөд бидэнтэй хамт ажилладаг бусад эмэгтэйчүүд ч гэсэн адилхан байв. Яаж бид бүгд ийм адилхан байж болох юм бэ?

Бид эмчтэй ярилцахаар явлаа. Маш олон шинжилгээний дараа юу ч олоогүй ба эмч биднээс ажил дээрээ ямар химийн бодис хэрэглэдэг вэ гэж асуусан. Бид мэдэхгүй байлаа. Бид уг бодисыг яаж олохоо ч мэдэхгүй байв. Тэр бидэнд химийн бодисын савны хаяган дээрээс хаанаас ирснийг нь харж болно гэв. Тэдгээр нь маш урт нэртэй байсан ч бид түүнийг үсэг үсгээр нь цээжилж, шөнө нь өөрсдийн дотуур байрандаа бичиж авах ёстой боллоо. Бид жагсаалтаа эмч дээр авч очсон. Эмч тэндээс хоёр бодис олж, тэр хоёрын нэг нь буюу 2-Бромпропан нь эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг болохыг харуулсан. Дарга энэ химийн бодисыг сонгохдоо биднийг хүүхэдтэй болж чадахгүй, тиймээс бид гэр бүлийн үүрэг хариуцлагагүйгээр бүхий л үед ажиллах болно гэж сонгосон гэж бид бодох болсон юм. Тиймээс бид бүгд маш их ууртай байв.

Эмч бидэнд үйлдвэрийнхээ хөдөлмөрийн эрүүл мэндийн менежертэй ярилц гэж хэлсэн. Тэд хэлэхдээ ийм байдлаар шаналж байгаа хүмүүс нь зөвхөн та нар биш гэсэн. Бас энэ нь зөвхөн эмэгтэйчүүд биш, эрэгтэйчүүдэд ч мөн нөлөөлнө гэж хэлсэн. Хөдөлмөрийн эрүүл мэндийн үндэсний хүрээлэн болон Хөдөлмөрийн яам энэ талаар шалгалт хийж хэд хэдэн ажиллагчдын нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудал нь 2-Бромпропанаас болж байсныг олж тогтоолоо. Засгийн газар тус компанийг 2-Бромпропаныг хэрэглэхийг хориглосон юм. Тэд ч бидний эрүүл мэндэд хохирол учруулсандаа нөхөн төлбөр төлөх ёстой болсон билээ.



Зарим химийн бодисоос шалтгаалж нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудал үүсдэг

Ацетон (хуудас 673) ЛЕД болон чип цэвэрлэх үйлдвэрлэлд хэрэглэгддэг ба эрэгтэй хүний үр тогтоох чадвар буурах болон үр зулбалтын шалтгаан болдог.

Бензол (хуудас 665) Чип болон PCB цэвэрлэх үйлдвэрлэлд хэрэглэдэг ба эрэгтэй хүний үр тогтоох чадварыг бууруулдаг, сарын тэмдгийн мөчлөг алдахад хүргэдэг, бас жирэмсэн эмэгтэйн цус багадалт, мөн эхийн хэвлий дэх урагт сөрөг нөлөө үзүүлэх шалтгаан болдог.

Кадми (хуудас 646) гагнах болон угсрахад хэрэглэдэг ба эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нөхөн үржихүйн системийг гэмтээж болно. Мөн төрөлхийн гажиг үүсгэж, түрүү булчирхайн хорт хавдрын шалтгаан болж болно.

Нүүрстөрөгчийн тетрахлорид (хуудас 667) чип угсрах болон цэвэрлэх үйлдвэрлэлд хэрэглэдэг ба төмсөгний үрэвсэл, эрэгтэй хүний үргүйдэлд хүргэж, эхийн хэвлий дэх урагт сөрөг нөлөө үзүүлдэг.

Гексан (хуудас 663) Хувцасны болон электроникийн үйлдвэрт цэвэрлэгч, мөн гутлын үйлдвэрийн цавуунд ашигладаг ба эрэгтэй хүний үр тогтоох чадварыг бууруулах шалтгаан болдог.

Хар тугалга (хуудас 646) Батарей, өнгөт хуванцар, паалан болон будганд хэрэглэдэг ба сарын тэмдгийн асуудал, төрөлхийн гажиг болон хүүхдийн суралцах чадварт муугаар нөлөөлж болно.

Трихлорэтилен(ТСЕ) (хуудас 667) Хувцасны үйлдвэрт тодорхой хэсгийг цэвэрлэхэд, электроникийн үйлдвэрт гагнах, угсрах, цэвэрлэх, нийлүүлэхэд хэрэглэдэг ба төрөлхийн гажгийн шалтгаан болдог.

Толуол (хуудас 665) Гутлын үйлдвэрт цавуунд, электроникийн үйлдвэрт гагнах, угсрах, цэвэрлэхэд ашигладаг ба гаж нөлөө үүсгэх шалтгаан болдог.

Ксилол (хуудас 665) Чип, PCB, LCD, бас ЛЕД угсрах, цэвэрлэх үйлдвэрлэлд ашигладаг ба төрөлхийн гажиг үүсгэх шалтгаан болж болно.

Нөхөн үржихүйн систем болон хорт хавдрын талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл 501-502 дугаар хуудсыг үз.

Нөхөн үржихүйн эрүүл мэндэд хор нөлөөтэй химийн бодисын талаар илүү дэлгэрэнгүй мэдээллийг ХАВСРАЛТ Б: Түгээмэл химийн бодис, материал хэсгээс үзнэ үү.

Илүү аюулгүй химийн бодисын төлөөх үйл ажиллагаа

Ямар химийн бодистой ажиллаж байгаа талаараа аль болох их мэдээлэл олж мэд. Хэрвээ ажил олгогч бодисыг хувааж эсвэл ажлын хэсэгт авчрахаасаа өмнө химийн бодисыг хольж байгаа бол үндсэн савнаас нь шошгыг нь ав.

Эрэгтэй, эмэгтэй хүмүүс нөхөн үржихүйн эсвэл бэлгийн эрүүл мэндийн асуудалтай байгаа шинж тэмдэг байгаа эсэхийг олж мэд. Энэ талаар ярих нь тааламжтай бус байж болох ч үйлдвэрт хэр их хүн дараах өвчин зовуурьтай байгаа болон хэр олон хүн амьсгалын замын үрэвсэл, өвчинтэй эсвэл тоног төхөөрөмжөөс болж өвдөж, гэмтсэнийг мэдэх нь чухал юм.

Ажилчдыг нөхөн үржихүүд учрах аюулаас хамгаалах бүлэгт элсүүлж эсвэл энэ бүлгийг үүсгэн байгуулах болон ХАБЭА-н мэргэжилтнүүд танд техникийн мэдээлэл болон бусад хувилбарын талаарх мэдээллийг ойлгоход тань туслах болно. Холбоод болоод хэрэглэгчдийн бүлэг нь ажил олгогч болон засгийн газрыг илүү аюулгүй химийн бодис хэрэглэхэд шахааж шаардахад тань тусалж чадна.

Үргүй болгодог химийн бодисыг АНУ-д хориглосон

Манай эхнэр бид хоёр хүүхэдтэй болох гэж оролдсон ч тэр жирэмсэн болохгүй байсан. Бид хоёулаа эмчид үзүүлэхэд хэвийн гэж гарсан ч миний үрийн шингэнд эр бэлгийн эс байхгүй байна гэж хэлсэн. Би зарим химийн бодис нь нөхөн үржихүйн асуудал үүсгэх шалтгаан болдгийг мэдэж байсан ба бараг 100 өөр төрлийн химийн бодистой ажилладаг байсан. Тиймээс эдгээрийн аль нь энэ асуудлын шалтгаан болж байгааг мэдэхэд хэцүү байсан.

Би хамтран ажиллагчидтайгаа ярилцаж, өөр бас олон хосууд хүүхэдтэй болж чадахгүй байгааг олж мэдлээ. Тэгээд би таван хосыг шинжилгээнд ор гэж ятгасан. Шинжилгээний дүнгээр бид зургуулаа асуудалтай, зарим нь цөөн эсвэл бүр огт эр бэлгийн эсгүй гэж гарсан. Манай Газрын тос, Химийн бодис болон Цөмийн үйлдвэр (зарим ган төмрийн үйлдвэр)-ийн үйлдвэрчний эвлэлээс биднийг эмчийн тусламж ав хэмээн явуулсан. Тэд хариуг хүлээн зөвшөөрсөн ба бидэнд илүү олон шинжилгээ хийж, бас хортой химийн бодист өртсөн нь асуудлын шалтгаан гэдэгтэй санал нэг байсан.

Үйлдвэрт амьтны нөхөн үржихүйн эрүүл мэндэд нөлөөлдөг 4-100 химийн бодис ашигладаг байсан болох нь ил болсон. Гэхдээ нэг химийн бодис буюу DBCP-г их хэмжээгээр ашиглаж байсан. Үйлдвэрчний эвлэл

DBCP үйлдвэрлэдэг хоёр өөр үйлдвэрийн ажилчдыг шинжлүүлэхэд хариу нь ижил байсан. DBCP болон үргүйдлийн асуудлын хоорондох холбоо нь уг бодис энэ гурван үйлдвэрийн бүх ажилчид нийтлэг хэрэглэж байсан ганц химийн бодис болохыг бид олж мэдэх үед тодорхой болсон.

Бид DBCP-г хориглуулахаар тэмцэж байх үед үйлдвэр бидэнд зөвхөн аюулгүй хэмжээгээр ашиглах хэрэгтэй гэж маргаж байв. Гэвч олон хүн аль хэдийн үргүй болсон байсан ба бид үүнийг цаашид үргэлжлүүлж чадахгүй байв. Ингээд манай үйлдвэрчний эвлэл Хэвлэлийн бага хурал хийж, Хүрээлэн буй орчныг хамгаалах агентлаг (EPA)-ын анхаарлыг татаж, эцэст нь тэд Калифорнид DBCP-г хэрэглэхийг хориглож, удалгүй улс даяар хориглов. Харамсалтай нь DBCP-г үйлдвэрлэхийг EPA хориглоогүй тул бусад муж улсууд болон дэлхий даяар ажилчдынхаа хүүхэдтэй болох аз жаргалыг хасаж, үйлдвэрлэлд үргэлжлүүлэн хэрэглэсээр байна.

Нөхөн үржихүйн системийн хорт хавдрыг эрт илрүүлэх

Хорт хавдар хэнд ч тохиолдож болно. Гэвч хорт хавдрыг эрт оношилсноор эмчлэх боломжтой. Нэг арга нь энгийн үзлэг шинжилгээ хийж хорт хавдрыг олж болно. Заримыг нь гэртээ өөрөө хийж болох бол заримыг нь эмнэлэгт хийлгэх хэрэгтэй.

Хөхний үзлэг

Эмэгтэй хүн бүр хөхөндөө яаж үзлэг хийхийг сурч чадна. Үүнийг сар бүр, сарын тэмдэг ирснээс хэд хоногийн дараа хий.

Хөхөө толинд харж, ямар нэгэн өөрчлөлт, булцгар эсвэл хонхорхой байгаа эсэхийг хар. Гараа толгой дээгүүр сунгаж, бас хөхөө тэгш байдалтайгаар хуруугаараа мэдрэн, хөхөө тойрог маягаар даран ямар нэгэн булцгар байгаа эсэхийг үз. Хөхний толгойгоо шах. Хэрвээ цус эсвэл өөр зүйл ялгарч байвал эмнэлгийн тусламж ав.

Хэрвээ жигд бус өвчингүй булцгар эсвэл таныг түлхэх үед хөдлөхгүй байгааг олж мэдвэл эмчид үзүүл.



Эрүүл
мэндийн
мэдээлэл

(үргэлжлэл)



Эрүүл
мэндийн
мэдээлэл

Энэ булцгар нь хорт хавдар мөн эсэхийг мэдэх цорын ганц арга нь үүнийг тэр чигээр нь эсвэл зарим хэсгийг нь авч лабораторид шинжлүүлэх явдал ба үүнийг “биопси” гэдэг.

Умайн хүзүүний үзлэг

Эмэгтэй хүн урт хугацаанд ямар ч шинж тэмдэггүйгээр умайн хүзүүний (умайн онгойх хэсэг) хорт хавдартай байж болдог. Үүнийг эрт илрүүлэхэд дараах хоёр аргыг ашигладаг:

Зөөлөн эдийн шинжилгээ (**Pap test**), эрүүл мэндийн ажилтан таны умайн хүзүүнээс бага зэрэг арьс зөөлөн эд хусаж аван лабораторид шинжлүүлдэг. Хариу нь эерэг гарвал та эмчлүүлэх хэрэгтэй гэсэн үг. Зөөлөн эдийн шинжилгээг 3 жил тутамд хийлгэ. Энэ нь өвдөлтгүй ба хэдхэн минут л болдог.

Цууны шинжилгээ (**Vinegar test**), мөн харааны хяналт гэж нэрлэдэг ба эрүүл мэндийн ажилтан бага зэрэг цагаан цуугаар умайн хүзүүний (хэрвээ өвдөхгүй бол) онгойх хэсэгт бүрэх ба эс нь цагаан болж байгаа эсэхийг үздэг. Хэрвээ цагаан болж байвал та зөөлөн эдийн шинжилгээ өгч хорт хавдар гэдгийг батлах хэрэгтэй эсвэл крио эмчилгээ буюу хөлдөөх эмчилгээнд орох хэрэгтэй.

Төмсөгний үзлэг

Эрэгтэй хүн төмсөгний үзлэгийг сард нэг удаа өөрөө хийж байх хэрэгтэй. Төмсөг тус бүрээ хуруу хоорондоо зөөлөн эргүүл. Булцгар, хавдар, өвдөлт эсвэл хэмжээ, хэлбэр юм уу, дүрсэнд нь өөрчлөлт орж уу үгүй юу гэдгийг мэдэр. Хэрвээ та ямар нэг зүйл олбол эмчид үзүүл. Энэ нь хорт хавдар мөн эсэхийг хэт авиагаар баталж болно. Төмсөгний хорт хавдар маш хурдан өсдөг тул сэжиг илэрвэл аль болох хурдан эмчилгээ хийлгэ.

Гэр бүл төлөвлөлт ба БЗХӨ-ий талаар боловсролтой болох

Олон хүн үйлдвэрт ажиллаж байх хугацаандаа ихэнх нь бэлгийн идэвхтэй үе дээрээ байдаг. Тиймээс тэд гэр бүл төлөвлөлт, бэлгийн эрүүл мэнд, бас хэрхэн бэлгийн замын халдварт өвчнөөс (БЗХӨ) урьдчилан сэргийлэх талаар мэдээлэлтэй байх нь чухал юм.

Ажилчид болон үйлдвэрчний эвлэл нь эмэгтэйчүүдийн байгууллага, эрүүл мэндийн ажилтан, мөн түүнчлэн засгийн газрын эрүүл мэндийн ажилтнуудад зориулсан ажлын хэсэг байгуулан доорх чиглэлд хамтран ажиллаж чадна:

- Хорт хавдрыг эрт илрүүлэх
- Гэр бүл төлөвлөлт
- БЗХӨ-ий шинжилгээ ба эмчилгээ, бас урьдчилан сэргийлэх

Ажлын хэсгээр дамжуулан хэлэлцүүлэг хийж, хэрхэн ажил, соёл, олон нийт, гэр бүл, бас хувийн

сонголт нь тэдний бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндэд нөлөөлдөг болох талаар олж мэдэхийг нь дэмжиж хүмүүст туслах нь хамгийн үр дүнтэй байдаг. Үүнд мөн үнэ төлбөргүй эсвэл хямд өртөгтэй эмнэлэг, засгийн газрын хөтөлбөрүүд, түүнчлэн үйлдвэрт сургах, үйлчилгээ үзүүлэх шилдэг аргууд зэрэг олон нийтийн нөөцийн талаарх мэдээллийг багтаасан байх ёстой.

Ажилчдын эрүүл мэндийн ажлын хэсэг нь үнэгүй эсвэл хямд үнэтэй БЗХӨ-ий шинжилгээ, эмчилгээ, жирэмсний халамж үйлчилгээ, хөхний үзлэг, умайн хүзүүний зөөлөн эдийн шинжилгээ, бас цууны шинжилгээ болон гэр бүл төлөвлөлтийн үйлчилгээг урьж чадна.

Энэ бүлгийн үлдсэн хэсэгт дараах хүснэгтэд дурдсан ажлын хэсгүүдэд хамаарах сэдвийн мэдээллээр хангах болно. Үйлдвэр дээрээ эрэгтэй, эмэгтэй хүмүүстэй ярилцаж, тэдний хувьд хамгийн чухал байгаа ажлын хэсгийн тухай асуудлыг олж баталгаажуулж, ярилц.



Хятадын ажилчин эмэгтэйчүүдийн сүлжээний эрүүл мэндийн машин манай үйлдвэрийн бүсэд ирж үнэгүй шинжилгээ бидэнд санал болгох хүртэл би pap test-ийн талаар огт сонсож байгаагүй.












Эрүүл
мэндийн
мэдээлэл


Гэр бүл төлөвлөлтийн талаарх мэдээлэл

Гэр бүл төлөвлөлтөд хэдэн хүүхэдтэй болохыг хүсэж байгаа болон хэзээ хүүхэд төрүүлэхийг хүсэж байгаа нь ордог. Хэрвээ та хүүхэдтэй болохоо азнахыг хүсэж байгаа бол жирэмслэлтээс сэргийлэх хэд хэдэн аргын нэгийг хэрэглэж болно. Эдгээр аргыг гэр бүл төлөвлөлт, жирэмслэлт хоорондын завсарлага эсвэл ерөндөг гэж нэрлэдэг. Эрэгтэй, эмэгтэй хүмүүст зориулсан бэлгэвч зөвхөн жирэмслэлтээс гадна мөн БЗХӨ-өөс сэргийлдэг. Арга тус бүр нь зарим хүмүүст бусад аргаасаа илүү үр дүнтэй байдаг. Дараагийн хуудсанд байх хүснэгтэд арга бүрийн давуу болон сул талыг харуулах болно. Аль нь танд илүү тохирох талаар эрүүл мэндийн ажилтантай ярилцаж, шийдээрэй.

Гэр бүл төлөвлөлтийн талаарх мэдээлэл

Гэр бүл төлөвлөлтийн төрлүүд	Жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх	ДОХ болон БЗХӨ-өөс хамгаалах	Хэр ойр ойрхон	Бусад чухал шаардлагатай мэдээлэл
Бэлгэвч 	Сайн	Сайн	Тухай бүр	Үрийн шингэн устгагч түрхлэг болон усан суурьтай чийгшүүлэгчтэйг нь хэрэглэх нь хамгийн үр дүнтэй. Бэлгэвчийг бэлгийн хавьталд орох бүртээ хэрэглэх хэрэгтэй.
Жирэмснийг хянах капсул 	Маш сайн	Огт үгүй	Өдөр бүр	Өдөр бүр тодорхой цагт хэрэглэж байх нь чухал. Хэрвээ та хөхний хорт хавдар, цусны даралт өндөртэй эсвэл элэгний өвчтэй болон жирэмсэн эсвэл сувилуулж байгаа бол эмчтэйгээ ярилц.
Ерөндөг 	Шилдэг	Огт үгүй	3-5 Жилд жил тутам	Тусгай бэлтгэгдсэн хүнээр ямар төрөл гэдгээс нь хамаарч 3 эсвэл 5 жил тутамд солиулж, шинийг хийлгэж бай.
Тариа	Маш сайн	Огт үгүй	1,2 эсвэл 3 сар	Ямар төрөл гэдгээс нь хамаарч 1-2 эсвэл 3 сар тутам давтан хэрэглэх хэрэгтэй.
IUD 	Шилдэг	Огт үгүй	5 эсвэл 12 жил	Тухайн төрлөөсөө хамааран 5 эсвэл 12 жилдээ үр дүнтэй. Тусгай бэлтгэгдсэн эрүүл мэндийн ажилтнаар тавиулж, бас авхуулж байх ёстой.
Сугалж гаргах (гадуур тавиулах) 	Наад захын	Огт үгүй	Тухай бүр	Эрэгтэй хүн бэлгийн хавьталд орох бүртээ сугалж гаргах хэрэгтэй. Хэдийгээр та сугалж гаргасан ч зарим шингэн нь бэлгийн хавьталд орж байх үед үтрээнд үлдэж жирэмслэх эсвэл БЗХӨ дамжих шалтгаан болдог.

<p>Хөхөөр хооллох (зөвхөн эхний 6 сард)</p> 	<p>Маш сайн</p>	<p>Огт үгүй</p>	<p>Өдөр болон шөнө хэдэн удаа хөхөөр хооллох</p>	<p>Энэхүү арга нь зөвхөн эмэгтэй хүн хүүхдээ хөхөөр хооллож, бас сарын тэмдэг ирээгүй байгаа тохиолдолд л үр дүнтэй.</p>
<p>Өндгөн эс ялгарч буй өдрүүдэд хавьтахгүй байх</p> 	<p>Сайн</p>	<p>Огт үгүй</p>	<p>Тухай бүр</p>	<p>Энэ арга нь жигд бус сарын тэмдэгтэй эмэгтэй хүнд тийм ч сайн үйлчлэхгүй.</p>
<p>Бэлгийн харилцаагүй секс (бэлэг эрхтэн умайд орохгүй)</p> 	<p>Шилдэг</p>	<p>Тухайн хүнээс хамаарна</p>	<p>Тухай бүр</p>	<p>Хэрвээ бэлэг эрхтэн үтрээнд хүрээгүй, ороогүй тохиолдолд жирэмслэхээс хамгаална. Бүдүүн гэдсээр болон аман сексээр БЗХӨ нь маш амархан дамждаг бол бэлгийн хүрэлтээр тэр бүр БЗХӨ дамждаггүй.</p>
<p>Эр, эм бэлгийн эсийг үр тогтоох чадваргүй болгох</p> 	<p>Шилдэг</p>	<p>Огт үгүй</p>	<p>Нэг удаа</p>	<p>Нэгэнт эрэгтэй эсвэл эмэгтэй хүн үр тогтоох чадваргүй болсон бол тэд хэзээ ч жирэмсэн болохгүй ба эсвэл хэн нэгнийг жирэмсэн болгох боломжгүй болно.</p>



Хүсээгүй жирэмслэлт

Олон эмэгтэй, тэдний бэлгийн хамтрагч, гэр бүлийн хүн нь олон нийт эсвэл ажлын байр нь тэднийг гэр бүл төлөвлөлтийн мэдээлэл, үйлчилгээ эсвэл аль нь илүү сайн сонголт болох мэдээлэл авах боломжоор хангаагүйгээс болж хүсээгүй жирэмслэлттэй нүүр тулгардаг.

Хуудас 504-т тодорхойлсны дагуу гэр бүл төлөвлөлтийн аргуудаас сонгон хэрэглэж жирэмслэлтээс урьдчилан сэргийлнэ. Онцгой нөхцөл байдалд гэр бүл төлөвлөлтийн эсвэл “маргааш өглөө нь” уух (буюу Б төлөвлөгөө, Постинор болон бусад) капсул гээд хэд хэдэн аргыг хамгаалалтгүй бэлгийн хавьгалд орсноос хойш 5 өдрийн дотор хэрэглэх ёстой.

Хэрвээ тэр эмэгтэй жирэмслэлтээ үргэлжлүүлэхгүй гэж шийдсэн бол абortoос гадна, боломжтой бол дараах гурван өөр төрлийн аргаас сонгож болно.

Эмээр үр хөндөх: Үүнийг мөн эмийн аборт гэдэг ба эмэгтэй хүн мисопротолыг дангаар эсвэл мисопростол болон мифепристоньг хослуулан хэрэглэснээр жирэмслэлтийг тасалдаг. Нэгэнт л эхийн хэвлийд юу ч үлдэхгүй тул үүнд халдвар авах аюул бага байдаг боловч их хэмжээний цус алдах нөхцөл гарч болно. Иймээс эмнэлгийн ойр байх ёстой.

Вакумаар үр хөндөх: Үүнийг мөн вакум соролт эсвэл MVA гэж нэрлэдэг ба тусгай хоолойг (хөндий зүү) үтрээн дундуур явуулж, умайн хүзүүгээр жирэмслэлтийг тусгай төрлийн зүүгээр сорж авдаг. Үүнийг эмнэлэгт эсвэл эмчийн өрөөнд 10 минутад хийж болдог.

Үр хөврөлийг хусах үр хөндөлт: Ди болон Си гэдэг ба жижиг хурц халбага хэлбэртэй багажаар саванд тогтсон үр хөврөлийг хусаж авдаг. Энэ нь ихэвчлэн мэс заслын өрөөнд 20 орчим минут болдог ба зарим үед уг эмэгтэйд унтуулах эм өгөх шаардлагатай болдог.

Аюултай орчинд хийсэн үр хөндөлт нь халдвар, өвдөлт, үргүүдэл, тэр бүү хэл заримдаа үхэлд хүргэж болно. Гэхдээ аюулгүй үр хөндөлт нь бага хор хохирол учруулдаг. Аюулгүй үр хөндөлт дараах шаардлагад нийцэх ёстой:

- Мэргэшсэн, туршлагатай эрүүл мэндийн ажилтан хийнэ;
- Зохих багаж хэрэгсэл, эм ашиглана;
- Цэвэр орчин нөхцөлд хийнэ. Үтрээ болон хэвлийд орж байгаа бүх зүйл нь халдваргүйжүүлсэн байх ёстой (нянгүй);
- Сүүлийн сарын тэмдэг ирснээс хойш 3 сараас хэтрээгүй хугацаанд тусгай багажтай эмнэлэгт хийнэ.

Эмэгтэй хүнд үр хөндөлт хийлгэх нь ихэвчлэн хүнд хэцүү байдаг. Үр хөндүүлэхийг хүсэж байгаа эсвэл хэрэгтэй байгаа эмэгтэйд хүндэтгэлтэй хандах хэрэгтэй. Амьдарч байгаа газрынхаа эмнэлэг, аюулгүй үр хөндөлтийн газруудын жагсаалттай байснаар эмэгтэйчүүдийн амийг аврахад тус болно. Мөн гэр бүл төлөвлөлтийн мэдээлэл авах боломжийг сайжруулснаар үр хөндүүлэх хэрэгцээ шаардлагыг багасгахад тус болно.



Бэлгийн замын халдварт өвчний (БЗХӨ) болон бэлгийн замын бусад халдварын талаарх мэдээлэл

Бэлгийн замын халдварт өвчин (БЗХӨ) нь бэлгийн хавьтлын үед нэг хүнээс нөгөөд дамждаг. Тэдгээр нь эмэгтэй, эрэгтэй хүнд, бас заримдаа хүүхдэд нөлөөлдөг. Мөн түүнчлэн зөвхөн үтрээгээр бэлгийн хавьталд орсноор жирэмсэн болж болох ба БЗХӨ нь аман болон шулуун гэдсээр секс үйлдэх зэрэг олон төрлийн сексээр халдварладаг. Заримдаа халдвартай хүний бэлэг эрхтнийг үрснээр БЗХӨ тусаж болно.

Бэлэг эрхтний зарим халдвар нь БЗХӨ биш байдаг ба шинж тэмдгийг нь тодорхойлж сурч болно. Хэрвээ эргэлзэж байвал тэр даруй шинжилгээ өг. Үтрээнээс гарах шингэний үнэр, өнгө эсвэл хэлбэр нь өөрчлөгдөж, үтрээний дотор болон гадна талд загатнах нь мөөгөнцөр эсвэл бактерийн халдвар байж болох ба энэ нь бэлгийн хавьтлаар халдварладаггүй. Мөөгөнцөр нь өөрөө аяндаа эсвэл мөөгөнцрийн эсрэг эм (буюу *micronazole*, *nystatin*, *clotrimazole* болон бусад) хэрэглэснээр зүгээр болно. Гэвч бактерийн халдвартай үед антибиотик уух хэрэгтэй болдог.

Хэрвээ өвдөлттэй шээх эсвэл шээх үед халуу дүүгэх, шээс муухай үнэртэх, булингартай харагдах эсвэл цустай, идээтэй байх нь шээсний замын халдвар (UTI)-тай болсон гэсэн үг юм. Энэ нь БЗХӨ биш. Маш их хэмжээний ус ууснаар халдварыг эмчилж болох ч 2 хоногийн дотор бие сайжрахгүй бол антибиотик (*cortimoxazole*) уух хэрэгтэй. Эрүүл мэндийн ажилтанд үзүүл.

БЗХӨ-ий түгээмэл шинж тэмдгүүд:

- Үтрээнээс гарах шингэн муухай үнэртэй байх;
- Бэлэг эрхтэн загатнах;
- Бэлэг эрхтэн өвдөх;
- Улайх, цэврүүтэх, үү гарах, тууралт гарах, цочрох, бэлэг эрхтэн, шулуун гэдэсний дотор, гадна эсвэл ойролцоо загатнах;

- Төмсгөнд өвдөлт үүсэх эсвэл хавдах;
- Бэлгийн хавьтлын үеэр өвдөх;
- Шээхэд өвдөх;
- Гэдэсний доод талд өвдөх;
- Бэлэг эрхтнээс цустай шингэн гарах.

БЗХӨ ямар ч шинж тэмдэггүй байх нь мөн түгээмэл юм. Олон эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүд БЗХӨ-тэй байдаг ч түүнийг мэддэггүй.

(үргэлжлэл)



Эрүүл
мэндийн
мэдээлэл

Жишээлбэл, ДОХ нь биед маш удаан хугацаанд ямар ч шинж тэмдэг үүсгэхгүйгээр байж чаддаг. Тиймээс ялангуяа бэлгэвчгүй бэлгийн хавьталд орсон бол тогтмол шинжилгээ хийлгэх нь чухал.

- **Заг хүйтэн ба хламид** нь амархан эмчлэгддэг. Нэгэнт л адил шинж тэмдэг илэрсэн бөгөөд хэрвээ та аль нэгээр нь өвчилсөн бол хоёуланг нь эмчил.
- **Трихомониаз** нь загатнуулдаг БЗХӨ ба ихэвчлэн эрэгтэй хүнд ямар ч шинж тэмдэг илрэхгүйгээр бусдад дамжсаар байдаг.
- **Тэмбүү** нь бэлэг эрхтэнд өвчингүй яр үүсгэх шалтгаан болдог. Яр аяндаа арилчихдаг тул эдгэчихлээ гэж бодох нь их байдаг ч өвчин нь биеийн бусад хэсэг рүү үргэлжлэн тархсаар байдаг. Хэрвээ эмчлэхгүй бол энэ нь ноцтой эрүүл мэндийн асуудал үүсгэж бүр үхэлд ч хүргэж болно.
- **Зөөлөн ярнаас** болж бэлэг эрхтэн болон хошногон дээр өвдөлттэй яр гарах шалтгаан болдог.
- **Бэлэг эрхтний герпес** бэлэг эрхтэн дээр эсвэл аман дээр өвчтэй яр гарах шалтгаан болдог ба гараад л арилаад л байдаг. Энэхүү вируст өвчнийг эмчлэх боломжгүй ч үүнийг багасгах эмчилгээ байдаг. Герпес нь маш амархан тархдаг ба яр гарсан үед бэлгийн хавьталд орж болохгүй бөгөөд бэлгийн хавьталд орох болбол бэлгэвч хэрэглэ.
- **ДОХ** маш ноцтой БЗХӨ бөгөөд хэрвээ ямар нэг арга хэмжээ авахгүй бол хүний дархлал хомсдолын вирус (ХДХВ)-д хүргэдэг. 30-р бүлгээс ДОХ-ын шинж тэмдэг, зохицуулалт, бас урьдчилан сэргийлэх талаар үзнэ үү.

Хэрвээ БЗХӨ-ий шинж тэмдгүүд байгаа бол:

- **Халдварыг тэр даруй эмчил.** Эмчид үзүүлж зөв антибиотик авч уу. БЗХӨ-өөс сэргийлэхэд хэрэг болохуйц мэдээлэл өгөхөд тусална уу гэж хүс.

Хэрэв эм
уугаад өвчний
шинж тэмдэг
арилахгүй байвал
эмчид үзүүл.
Өөр өвчин байж
магадгүй.



- **Хэт хүндрүүлэх хүртлээ битгий удаа.** Эрт эмчилгээ хийснээр ноцтой асуудал болж хүндрэх, халдварыг бусдад тараахаас урьдчилан сэргийлнэ;
- **Бэлгийн хамтрагчтайгаа яг ижил цагт эмчлүүл.** Хэрвээ та хоёрын аль нэг нь эмчилгээ хийлгээгүй бол бэлгийн хавьталд орох үед дахин халдааж болно;
- **Эмчилгээнд шаардлагатай бүх эмийг бүтэн уу.** Хэдийгээр шинж тэмдгүүд нь арилсан байсан ч гэсэн эмийн бүх тунг дуустал нь уухаас нааш өвчин эдгэрэхгүй;
- **Аюулгүй сексийн дадлага хий.** Аюулгүй секс гэдэг нь аль болох хамтрагчийнхаа бэлэг эрхтэн болон үрийн шингэнд шууд хүрэхгүй байх, багасгахыг хэлнэ. Бэлгийн хавьталд орох бүртээ бэлгэвч хэрэглэж, өөрийгөө болон хамтрагчаа БЗХӨ-өөс сэргийл;
- **ДОХ-ын шинжилгээнд ор.** ДОХ-ын халдвар нь ихэвчлэн БЗХӨ-тэй хамт илэрдэг.



Эрүүл
мэндийн
мэдээлэл